



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/110.

Мандалговь

Автомашины шатахуун зарцуулалтын
нормыг шинэчлэн тогтоохыг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “л” дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, “Жишиг норм батлах тухай” Зам тээвэр, хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн А/29 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хэмжилт, дүгнэлтийн дагуу төсвийн байгууллагуудын автомашинуудын 100 километр зарцуулах шатахууны нормыг тогтоон мөрдөж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван), Санхүүгийн хяналт, аудитын алба (Г.Зоригт), төсвийн шууд захирагч нарт тус тус даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

481210306